

"ТӨРӨӨС ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО"-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН (2018 оны жилийн эцсийн байдлаар)

2019 оны 03 дугаар сарын 29

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд 2018 онд хийсэн ажлын биелэлт, тухайн ажлыг хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж ярилцах, холбогдох статистик мэдээ, мэдээллийг ашиглан хийв.

ХОЁР. БОДЛОГЫН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ыг УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоол, эхний үе шат (2016-2020 он)-ны төлөвлөгөөг ХХАА-н сайдын 2016 оны “Төлөвлөгөө батлах тухай” А-60 дугаар тушаалаар баталсан.

Бодлогын зорилго: Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжил нь үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэн өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэгдэнэ.

Бодлогын зорилтууд:

Зорилт 1. Мал аж ахуйн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт нэмэгдүүлэх;

Зорилт 2. Тариалангийн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх;

Зорилт 3. Хүнсний аюулгүй байдал, боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;

Зорилт 4. Судалгаа ба хөгжлийн үйл ажиллагааг дэмжих;

Зорилт 5. Хөрөнгө оруулалт, худалдааг нэмэгдүүлэх;

Зорилт 6. Хүний нөөцийг чадавхжуулах;

Бодлогыг хэрэгжүүлэх үе шат:

- ✓ I үе шат /2016-2020 он/;
- ✓ II үе шат /2021-2025 он/;

Бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн

- ❖ Хөдөө аж ахуйн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүний 5 жилийн дундаж өсөлтийг 20 хувь,
- ❖ Нийт төсөвт хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувийг 4 хувь,
- ❖ Нийт сүрэгт үхрийн эзлэх хувийг 10 хувь,
- ❖ Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээг 200 мянган тонн,
- ❖ Нийт сүү үйлдвэрлэлд үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний эзлэх хувийг 50 хувь,
- ❖ Тариалангийн эргэлтийн талбайг 1050 мянган га,
- ❖ Буудайн га-гийн ургацыг 20 центнер,
- ❖ Хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах түвшинг 100 хувь,
- ❖ Тэжээл үйлдвэрлэлд бүрэн найрлагат тэжээлийн эзлэх хувийг 10 хувьд тус тус хүргэнэ.

ГУРАВ. БОДЛОГЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН:

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичигт тусгагдсан хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг 2018 оны жилийн эцсийн байдлаар 64.4 хувьтай үнэлэгдэв.

№	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт - 2014 он	Хүрэх түвшин - 2020 он	Хүрсэн түвшин	Үнэлгээ	2025 он
1	Хөдөө аж ахуйн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүний 5 жилийн дундаж өсөлт (хувиар)	12.0	15.0	14.1	100.0	20
2	Нийт төсөвт хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь	2.0	3.0	1.9*	0.0	4
3	Нийт сүрэгт үхрийн эзлэх хувь	6.7	8.0	6.6	0.0	10
4	Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах /мянган тонн/	16.8	100.0	53.1	70.0	200
5	Нийт сүү үйлдвэрлэлд үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний эзлэх хувь	9.0	30.0	10.0	40.0	50
6	Эргэлтийн талбай /мянган га/	769.0	960.0	905.0	100.0	1050
7	Буудайн га-гийн ургац /центнер/	16.9	17.3	13.7	70.0	20
8	Хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах түвшин (хувиар)	54.0	70.0	60.0	100.0	100
9	Тэжээл үйлдвэрлэлд бүрэн найрлагат тэжээлийн эзлэх хувь	0.7	5.0	5.0	100.0	10
Дундаж үнэлгээ					64.4	

Тайлбар:

*- Суулийн 3 жилийн өсөлтийн дундаж үзүүлэлтийг суурь үзүүлэлт дээр нэмж тооцов.

ЭМ-ийн сайдын 2017 оны "Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, амин дэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ батлах тухай" А-74 дүгээр тушаалаар хоногт хэрэглэх хүнсний ногооны хэмжээ шинэчлэгдсэнээр /200 гр байсан 260 гр/ хүрсэн түвшин буурсан тул 8 дугаар үзүүлэлтийн биелэлтийг 100 хувиар тооцов.

Үр дүнгийн 9 дүгээр үзүүлэлтийн хүрээнд "Түмэн шувуут", "Милл хаус", "Баялаг эмээлт" зэрэг тэжээлийн үйлдвэр 2015 оноос үйл ажиллагаа явуулж байна. Шувууны тэжээлийн 40, гахйан тэжээлийн 30 гаруй хувь, малын тэжээлийн тодорхой хувийг эдгээр үйлдвэрээс нийлүүлж байна.

“Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын эхний үе шатны /2016-2020 он/ төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд нийт 176 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 6 дугаар хавсралтын дагуу шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг бүрэн тодорхойлоогүй, жил жилээр нарийвчлан тусгаагүй байгаа тул бодлогын баримт бичигт заасан 9 шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр дүнгийн үнэлгээг хийв.

“ТӨРӨӨС ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”-ЫН 2018 ОНЫ ХЭРЭГЖИЛТ 49.0 ХУВЬТАЙ ҮНЭЛЭГДЛЭЭ.

Хүснэгт 1

№	Зорилт	Арга хэмжээний тоо	100%	70%	40%	0%	Үнэлэх боломжгүй	Биелэлт, хувиар
1	I зорилт	69	17	16	26	8	2	57.6
2	II зорилт	42	1	11	18	10		39.8
3	III зорилт	27	0	5	11	11		29.3
4	IV зорилт	12	4	7	1	0		77.5
5	V зорилт	18	0	6	6	2	4	47.1
6	VI зорилт	8	0	2	5	1		42.5
	Нийт	176	23	45	68	32	6	49.0

“Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт /Хүснэгт 1/-ийн удаашралтай, үр дүнгүй, үнэлэх боломжгүй арга хэмжээг тухайн зорилт бүрээр авч үзвэл:

НЭГ. МАЛ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭЛТ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Энэхүү зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 69 арга хэмжээний биелэлт 57.6 хувиар үнэлэгдэв. Эдгээрээс 17 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн бол үр дүнгүй арга хэмжээ 8 байна. Үүнд:

- Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлж, гарал үүслийн баталгаажуулалтын суурь нөхцөлийг бүрдүүлэх
- Малыг болон тэжээвэр амьтдын үржлийн ажлын стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх.
- Мал эмнэлгийн клиник үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.
- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд тэжээл тариалах зориулалтаар тариалангийн газрыг ашиглуулах нөхцөлийг бүрдүүлэх
- Отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх
- Малыг тэжээл бэлтгэл, бордоо үйлдвэрлэлд дэвшилтэт техник, технологи нутагшуулах
- Малыг гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний стандартыг шинэчлэн тогтоох
- Мал, амьтны дотор мах, дайвар бүтээгдэхүүн боловсруулалт, боруулалтын сүлжээг дэмжих

Үнэлэх боломжгүй буй арга хэмжээ:

- Монгол Улсын үржлийн шилмэл малын дэвтэр бий болгож, мал бүхий иргэн, хуулийн этгээдийн малын чанараа сайжруулах идэвх, хөрөнгө оруулалтыг сөдөөх,
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг нэмэгдүүлэх зэрэг 2 арга хэмжээний шалгуур үзүүлэлт тодорхой бус, тайлагналт хангалтгүйгээс үнэлэх боломжгүй байна.

ХОЁР. ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Уг зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 42 арга хэмжээний биелэлт 39.8 хувиар үнэлэгдэв. Үүнээс: 1 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 11 арга хэмжээ 70 хувийн хэрэгжилттэй бол эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээ 18, үр дүнгүй арга хэмжээ 10 байна. Үүнд:

Үр дүнгүй арга хэмжээ.

- Төвийн бүсэд тариалангийн газрын боломжит орон зайн ашиглалтыг сайжруулах,
- Орон зайн мэдээллийн системийг тариалангийн газар ашиглалтад нэвтрүүлэх,
- Салбарын яамны харьяанд мэргэжлийн эрдэм шинжилгээний хүрээлэнг ажиллуулах, таримал ургамлын үр сортын болон ургамал хамгааллын нэгжийг байгуулах,
- Сэлгээнд оруулах таримлын тоог нэмэгдүүлэх талаар тариаланчид, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллаж, сургалт зохион байгуулах,
- Гидротехникийн барилга байгууламж, боомт усанг шинээр барих, сэргээн засварлахад дэмжлэг үзүүлэх,
- Дэвшилтэт техник, технологитой усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэн, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,
- Химийн гаралтай пестицид болон ургамал хамгааллын цогц аргыг зохистой, хор аюулгүй, үр дүнтэй ашиглах мэдлэгийг тариаланчдад олгох, сурталчлах,
- Олон улсын ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн стандартыг нутагшуулах, батлуулах,
- Жимс, жимсгэний аж ахуй байгуулахад урт хугацаатай зээлийн дэмжлэг үзүүлж, баталгаат сортын суулгацын тариалалтыг 15.0 мянган га талбайд хүргэх,
- Тариалангийн бүсэд эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хослон эрхлэх, ашигт таримлын үрийг үржүүлж, дотоодын хэрэгцээг хангах, нөөц бүрдүүлэх,

Эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээ:

- Тариалангийн талбайд ойн зурвас байгуулах ажлыг эрчимжүүлэх,
- Тариалангийн аж ахуйг түшиглэн эрчимжсэн аж ахуйн эрхэлж байгаа аж ахуйн туршлагыг дэлгэрүүлж сурталчлах, зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлэх
- Хүнсний ногооны 20 нэр төрлийн үрийг дотоодын үйлдвэрлэлээр хангах,
- Монголын үндэсний төмсний шинэ сортын үр үйлдвэрлэх, вирусгүй бичил булцуугаар дотоодын хэрэгцээг хангах,
- ХАА-н техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх, санхүүгийн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх,
- ХАА-н зарим машин, багаж, эд ангийг дотоодод үйлдвэрлэх, угсрах үйлдвэр байгуулах,
- Услалтын систем шинээр барьж сэргээн засварлахад хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх,
- Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтад зориулсан намираа, дуслын усалгаа, бороожуулагч тоног төхөөрөмж олгоход дэмжлэг үзүүлэх,
- Тариаланчдын ургамлын хөнөөлт организмтай зохистой аргаар тэмцэж байгаад хяналт тавих зорилгоор тариаланчдыг талбайн түүх хөтлөх аргад суралцуулах, хэвшүүлэх,
- Монголд ургах боломжтой жимс, жимсгэний суулгац үржүүлгийн плантацуудыг бүсчлэн байгуулах, баталгаат сортын суулгацаар тасралтгүй хангах,
- Хүйтэнд тэсвэртэй жимсний сортуудыг турших, нутагшуулах, монгол сорт гаргах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх,
- Чацарганы тариалалт, хураалт, хадгалалт, боловсруулалтын нэгдсэн өртгийн сүлжээг хөгжүүлэх, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, экспортлох,
- Үр тариа, тэжээл, буурцагт ургамлын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг бүрэн хангах, экспортын чиг баримжаатай хөгжүүлэх,
- Хүлэмжийн аж ахуй байгуулахад дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, урт хугацаатай зээлийн дэмжлэг үзүүлэн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,
- Зуны хүлэмж худалдан авах, дотооддоо үйлдвэрлэхэд иргэн, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх,
- Төмс, хүнсний ногоог ялгах, савлах, хатаах зэрэг хадгалалтын шинэ аргуудыг нэвтрүүлэх, орон нутагт зоорийн аж ахуйг хөгжүүлэх,
- Тариалангийн хуульд заасны дагуу тариалангийн аж ахуй бүрийг агрономич, инженертэй байх арга хэмжээг авч ажиллах зэрэг болно.

ГУРАВ. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Уг зорилтын хүрээнд 27 арга хэмжээний биелэлт 29.3 хувиар үнэлэгдэж, “Төрөөс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын нийт 6 зорилтоос хамгийн бага хэрэгжилттэй байна. Үр дүнтэй хэрэгжсэн арга хэмжээ 0, тодорхой үр дүнд хүрсэн арга хэмжээ 5, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээ 11, үр дүнгүй арга хэмжээ 11 байна.

Үр дүнгүй арга хэмжээ.

- Мал, амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хүлээн авах, анхан шатны болон хагас боловсруулалт хийх нөхцөлийг бүрдүүлэх, хадгалалт, тээвэрлэлт, боловсруулалт, борлуулалтын сүлжээг өргөжүүлэх,
- Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог төлөвшүүлж хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх,
- Малын эм, бордоо, ургамал хамгааллын бэлдмэл, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх үлдэгдэл бодис, тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг тодорхойлох чадавх, хяналтыг сайжруулах,
- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах салбар дундын уялдааг сайжруулах,

- Зохицуулах үйлчилгээтэй хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох,
- Органик болон зохицуулах үйлчилгээтэй хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх,
- Нийтийн хоолны үйлдвэрлэлд зэрэглэл тогтоох эрх зүйн зохицуулалтыг бий болгох,
- Нийтийн хоолны үйлдвэрлэлийн зэрэглэл тогтоох арга хэмжээг хэрэгжүүлэх,
- Хоолны газрын жор технологийг боловсруулах,
- Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг мөрдүүлэх,
- Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд түүхий эд бэлтгэн нийлүүлэлт, хагас боловсруулсан бүтээгдэхүүний үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн хүнсний хангамжийн ложистикийг бий болгох зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх,

ДӨРӨВ. СУДАЛГАА БА ХӨГЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Зорилтын хүрээнд 12 ажил төлөвлөсөн нь 77.5 хувьтай үнэлэгдэв. Үүнд: үр дүнд хүрсэн 4, тодорхой үр дүнд 7, эрчимжүүлэх шаардлагатай 1 арга хэмжээ байна.

Үр дүнгүй арга хэмжээ.

- Уул уурхайн татварын орлого, нөөц ашигласны болон тусгай зөвшөөрлийн төлбөрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарын судалгаа хөгжлийн сан бүрдүүлж, зарцуулах;

ТАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДААГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Тус зорилтын хүрээнд 18 арга хэмжээ төлөвлөж, 47.1 хувьтай хэрэгжсэн байна. Үр дүнд хүрсэн 0, тодорхой үр дүнд хүрсэн 6, эрчимжүүлэх шаардлагатай 6, үр дүнгүй арга хэмжээ 2 байгаа бол үнэлэх боломжгүй 4 арга хэмжээ байна.

Үр дүнгүй арга хэмжээ.

- Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг нэг цонхны бодлогоор явуулах;

Үнэлэх боломжгүй арга хэмжээ. Шалгуур үзүүлэлт тодорхой бус, хэрэгжилтийг үнэлэх хангалттай мэдээлэл байхгүйгээс үнэлэх боломжгүй.

- Үнэ цэнийн сүлжээний санхүүжилтийн цогц бүтцийг бий болгож, шаардлагатай шатанд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Эрсдлийг бууруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтворжуулахад даатгал, давхар даатгалын тогтолцоог цогц байдлаар нэвтрүүлэх;
- Дэвшилтэт технологи нэвтрүүлэх, нутагшуулах, салбарын судалгаа ба хөгжлийн хөрөнгө оруулалтыг дэмжих;
- Хүнс, хөдөө аж ахуйн салбарт санхүүгийн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх, төлөвшүүлэх;

ЗУРГАА. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Нийт 8 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, 42.5 хувийн хэрэгжилттэй байна. Үр дүнтэй 0, тодорхой үр дүнд хүрсэн 2, эрчимжүүлэх шаардлагатай 5, үр дүнгүй 1 арга хэмжээ байна.

Үр дүнгүй арга хэмжээ.

- Салбарын мэргэжилтэн, инженер техникийн болон бусад мэргэжилтэй ажилтны төгсөлтийн дараах болон мэргэжил дээшлүүлэх сургалтыг явуулах зайн сургалтын

тогтолцоог хөгжүүлэх, мэргэжлийн ур чадварыг тодорхойлох, мэргэшлийн зэрэг олгох;

Эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээ.

- Малчин, мал зүйч, зохиомол хээлтүүлгийн техникч, малын эмчийн хөдөлмөрийг хүнд, хортой нөхцөлд хамааруулах, гэрээт ажилчид, малчдын нийгмийн хамгааллын баталгааг ажил олгогчоор хангуулах;
- Малчин, мал зүйч, зохиомол хээлтүүлгийн техникч, малын эмчийн хөдөлмөрийг хүнд, хортой нөхцөлд хамааруулах, гэрээт ажилчид, малчдын нийгмийн хамгааллын баталгааг ажил олгогчоор хангуулах;
- Малчид, тариаланчдын ая тухтай амьдрах, тогтвортой ажиллах нөхцөлийг сайжруулах, малчин эмэгтэйчүүд, залуу малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх;
- Агрономич, механикжуулагч, инженер техникийн ажилтныг тариалангийн аж ахуйн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан бэлтгэх, сургалтын орчныг сайжруулах, сургалтын агуулгыг олон улсын жишигт нийцүүлэх, үйлдвэрлэлийн дадлагыг сургалттай хослуулахад чиглүүлэх;
- Нүүдлийн соёл, иргэншил, уламжлалд суурилсан аялал, жуулчлалыг малчдын ахуй амьдралд түшиглэн хөгжүүлэх зэрэг болно.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын хүрэх үр дүнгийн хэрэгжилтийн үнэлгээ 2018 оны жилийн эцсийн байдлаар 64.4 хувь, 2018 оны төлөвлөгөөний хэрэгжилт 49.0 хувь байна.
2. Бодлогын баримт бичгийн зорилгоос сайн хэрэгжилттэй нь “Судалгаа ба хөгжлийн үйл ажиллагааг дэмжих” /77.5%/, бага хэрэгжилттэй нь “Хүнсний аюулгүй байдал, боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” (28.1%) зорилт байна.
3. “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд анх удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн тодорхой бус байдал нь хүндрэл учруулж байна.
4. Мал аж ахуйн салбарт “Малын генетик нөөцийн тухай”, “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийг мөрдөж эхэлсэн нь биелэлтэд эерэг нөлөөг үзүүлсэн байна.
5. Гадаадын төслийн хүрээнд салбарт хэрэгжүүлж байгаа ажлыг тайланд тусгаагүй, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг өссөн дүнгээр гаргаагүй, салбарын статистик мэдээлэл бүрэн бус, хариуцсан мэргэжилтнүүдийн тайлагналтад хандаж байгаа хандлага зэрэг нь хэрэгжилтийн үнэлгээнд сөргөөр нөлөөлж байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

1. ХХАА-н сайдын 2016 оны А-60 дугаар тушаалаар баталсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын эхний үе шат (2016-2020 он)-ны төлөвлөгөөг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 2 дугаар хавсралтаар баталсан загварын дагуу шинэчлэн батлуулахыг БТГ-т;
2. Төлөвлөгөөг шинэчлэн батлуулахдаа үр дүнд чиглэсэн, хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхойлох, “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль” болон дээрх журмын хүрээнд тайлагнаж хэвшихийг бүх хэрэгжилтийн газруудад;
3. “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын биелэлтийг гаргахдаа урт хугацааны бодлогын баримт бичиг гэдгийг анхаарч, хэрэгжилтийг зөвхөн тайлант оноор бус өссөн дүнгээр тайлагнах, гадаадын төслийн хүрээнд салбарт хэрэгжүүлж

байгаа ажлыг тайланд тусгах, салбарын статистик мэдээллийг тайлагналтад бүрэн ашиглах, мэргэжилтнүүдийн ажилдаа хандах хандлагыг сайжруулах, чадавхжуулж ажиллахыг хэрэгжилтийн газрууд болон Төрийн захиргааны удирдлагын газарт,

- a. Сургалтын бодит хэрэгцээг тодорхойлох судалгаа авах, шалгуур үзүүлэлтийн дагуу хүрсэн түвшинг тогтоох, Тухайлбал: “Аж ахуй бүр агроном, инженертэй болсон байх” шалгуур үзүүлэлтийн биелэлтийг жил бүр гаргадаг ч албан ёсны статистик тоон мэдээлэлгүй, баримт нотолгоогоор баяжигдаагүйг анхаарах,
 - b. Зорилт, үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн тайлагнах, тоо, хэмжээ заасан биелэлтийг гаргахдаа явцыг тооцож, тоон утгаар дүнг илэрхийлж тайлагнаж хэвших,
 - c. Ажлын үр нөлөөг дээшлүүлэх үүднээс хэмжих нэгж, шалгуур үзүүлэлт тодорхой, зорилтот түвшинг үнэн зөв тодорхойлох, төлөвлөгөөний дагуу тайлагнаж хэвших, *Тухайлбал:*
 - i. “2.8.3. Тариаланчдын ургамлын хөнөөлт организмтой зохистой аргаар тэмцэж байгаад хяналт тавих зорилгоор тариаланчдыг талбайн түүх хөтлөх аргад суралцуулах, хэвшүүлэх”
 - ii. *Биелэлт нь:* талбайн түүх хөтлөх дэвтрийг боловсруулан 1500 хувь хэвлүүлсэн ба Сэлэнгэ, Төв, нийслэлийн төмс, хүлэмжийн ногоо үйлдвэрлэгч нарт зориулсан сургалтын үеэр тариаланчдад олгосон.
 - iii. *Үр дүн, цаашид авах арга хэмжээ:* Шалгуур үзүүлэлтийг үе шаттай, оновчтой төлөвлөөгүйгээс зорилтод заасан арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй, гол үр дүнг илтгэх хэрэгжилтийн ажлууд орхигдох эсвэл тайлагнахгүй байх нөхцөл байдал үүсэж байна.
4. “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай” хуулийн 8.6 дахь хэсэгт заасны дагуу бодлогын хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг 2020 онд зохион байгуулах,
5. Үр дүнгүй болон эрчимжүүлэх шаардлагатай, үнэлэх боломжгүй арга хэмжээ тус бүрийг хэрэгжилтийн газрууд анхааралдаа авч, хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах зэрэг болно.